



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/976

Мандлаговь

Аймгийн түүх, өв соёл, уран сайхны  
архив бүрдүүлэхэд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.5 “а”, 30.1.17, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.8, 16.1.12, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 11 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг угтан аймгийн түүх, өв соёл, уран сайхны архив бүрдүүлэхэд шаардлагатай хөрөнгийг гаргасугай.
2. Архив бүрдүүлэхэд шаардагдах 1,350.000 (Нэг сая гурван зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210827